



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 77

Улаанбаатар хот

Шагналд уламжлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улсад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа зарим хүмүүсийн хөдөлмөр бүтээлийг үнэлж, Төрийн дээд шагнал, цол, одон медалиар шагнуулахаар тодорхойлсон байгууллага, хамт олны саналыг дэмжиж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд уламжилсугай. Үүнд:

МОНГОЛ УЛСЫН “ГАВЬЯАТ ЭДИЙН ЗАСАГЧ ЦОЛ”-ООР:

1. Цүлтэмийн Цэнд “Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн Ерөнхий зөвлөх

МОНГОЛ УЛСЫН “ГАВЬЯАТ ТЭЭВЭРЧИН ЦОЛ”-ООР:

1. Хөхийн Чимэд Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны ахмад настан

“ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОН”-ООР:

1. Сүхбатын Санжааванчиг Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны ахмад настан

“АЛТАН ГАДАС ОДОН”-ООР:

1. Цэнд-Аюушийн Ганболд Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч
2. Цэндийн Содхүү Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч, Засаг даргын орлогч

3. Баяраагийн Алтансаргай	Чингэлтэй дүүргийн Хөдөлмөрийн хэлтсийн нягтлан бодогч
4. Чимэдийн Эрдэнэчимэг	Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн дотрын тасгийн эрхлэгч
5. Жавханы Сүрэнчимэг	Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн Хүүхдийн тасгийн эрхлэгч
6. Дашнямын Цэрэндулам	Чингэлтэй дүүргийн 5 дугаар сургуулийн ахмад багш
7. Доржийн Ганбаатар	“Нэйшнл лайф” даатгал ХХК-ийн Дэд захирал
8. Балдангийн Ванчиндорж	“Тайга инвест” ХХК-ийн Геологич
9. Сүхбаатарын Тамир	Чингэлтэй дүүргийн 23 дугаар сургуулийн Математикийн багш
10. Лодойн Нямандэлэг	Чингэлтэй дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн Улсын ахлах байцаагч
11. Шагжийн Эрдэнэчимэг	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын Улсын байцаагч
12. Лантуугийн Долгорсүрэн	Чингэлтэй дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн Улсын байцаагч
13. Самбуугийн Алтанцэцэг	Чингэлтэй дүүргийн 8 дугаар хорооны иргэн

“ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ”-ИАР:

1. Баатарын Энхтунгалаг	“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн Дэд захирал
2. Сандангийн Ганхуяг	ЭБЭГ ХХК-д Дизельчин
3. Үрчгэрийн Тэгшбаатар	Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч, Бизнес Инкубатор төвийн Нярав
4. Мягмаржавын Чимгээ	Чингэлтэй дүүргийн 23 дугаар сургуулийн Технологийн багш
5. Содномдаржаагийн Алдармаа	Чингэлтэй дүүргийн 23 дугаар сургуулийн багш
6. Жамбалсүрэнгийн Баасансүрэн	Чингэлтэй дүүргийн 83 дугаар цэцэрлэгийн Эрхлэгч

- | | |
|------------------------------|---|
| 7. Цэндсүрэнгийн Баатарсүрэн | “Баянманлай” ХХК-ийн Жолооч, худалдагч |
| 8. Жаргалын Дэлгэрцэцэг | “Баянманлай” ХХК-ийн Нягтлан бодогч |
| 9. Нанзадын Оюунчимэг | Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын туслах |

“ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ”-ИАР:

- | | |
|------------------------|---|
| 1. Баатарын Болдбаатар | Чингэлтэй дүүрэг дэх Цагдаагийн 2 дугаар хэлтсийн Ахлах байгцаагч, Цагдаагийн ахмад |
| 2. Сүхийн Баярсайхан | Чингэлтэй дүүрэг дэх Цагдаагийн 2 дугаар хэлтсийн Хэсгийн байцаагч |

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 78

Улаанбаатар хот

Шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 165 дугаар тогтоолоор баталсан “Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналын журам”-ыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж, эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажиллаж байгаа хавсралтад нэр дурдсан иргэдийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналаар шагнасугай.

2. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Чандмань одонгоор шагнагдах иргэдийн нэрсийг нэгдүгээр, Хурлын Хүндэт өргөмжлөлөөр шагнагдах иргэдийн нэрсийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Шагналд шаардагдах зардлыг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 12 сарын 12-ны
өдрийн 78 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



“Чандмань одон”-гоор шагнагдах хүмүүсийн нэрс

Д/д	Овог нэрс	Эрхэлсэн ажил, мэргэжил	Регистрийн дугаар
1.	Ч.Гончиг	Чингэлтэй дүүргийн “Ногоон булан” ахмадын амралтын зохион байгуулагч	ЙЛ89011817
2.	Б.Намнандорж	“Шинэ-Эхлэл” ТББ-ын дархан	Ш357083079
3.	Б.Пүрэв-Очир	“Даймонд-Очир” ХХК-ийн захирал	ЧК79032274
4.	А.Сүнжидмаа	“Эдваанс” ХХК-ийн ажилтан	Х378123006
5.	С.Батсайхан	“БЧЭС” ХХК-ийн захирал	ЦД73082611
6.	Ж.Нанжид	Чингэлтэй дүүргийн 15 дугаар хорооны иргэн	ХЖ50071419
7.	Ү.Тэгшбаатар	Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч	АГ79040338
8.	А.Жигжидсүрэн	Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хорооны иргэн	ХЙ61031469
9.	Ж.Жаргалсайхан	Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны иргэн	УХ64100610
10.	Д.Цээмээ	Чингэлтэй дүүргийн 6 дугаар хорооны иргэн	ХП64031801
11	Б.Алтанхуяг	Чингэлтэй дүүргийн 112 дугаар сургуулийн захирал	ЧЙ64050171
12	Б.Ганбаатар	Чингэлтэй дүүргийн 10 дугаар хорооны иргэн	ХГ57120204
13	Л.Долгорсүрэн	Чингэлтэй дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн Хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналтын улсын байцаагч	УВ61062405
14	М.Ууганбаатар	Чингэлтэй дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн Хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналтын улсын ахлах байцаагч	УЕ70062810
15	Ч.Ариунчимэг	Олон нийтэд түшиглэсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхөн сэргээх төвийн нийгмийн ажилтан	ГЖ74092009
16	Н.Даваасүрэн	Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны иргэн	Х374040207
17	Х.Чинзориг	Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга	ЭЮ81040211
18	Г.Цэндсүрэн	Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны Ахмад настан	ЖИ45031206
19	Б.Даваа	Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны Ахмад настан, Чөлөөт уран бүтээлч	ЕЮ55110818
20	Л.Сүх	“Баянбулаг” ХХК-ийн Захирал	ЧЙ57090375
21	С.Даваасүх	“Даймонд-Очир” ХХК-ийн дархан	ЗИ80101910
22	Ц.Бумцэнд	Чиглэл хязгаарлагдмал хувьцаат компанийн Захирал	ХГ60041034
23	А.Элбэгзаяа	Чингэлтэй дүүргийн 10 дугаар хорооны иргэн	ЗЖ43011017
24	С.Эрдэнэбулган	Чингэлтэй дүүргийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн дотоод ажил хариуцсан ажилтан	ЧМ66092102

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 12 сарын 12-ны
өдрийн 78 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



“Хүндэт өргөмжлөл”-өөр шагнагдах хүмүүсийн нэрс

Д/д	Овог нэрс	Эрхэлсэн ажил, мэргэжил	Регистрийн дугаар
1.	Г. Ганбаатар	“Ти-Си-Ти” ХХК-д харуул хамгалалтын ажилтан	ОЭ75111074
2.	Э.Цолмон	“Нарлаг тал” ХХК-д дархан	ТЕ75022171
3.	Ц.Намуунаа	“Сооц” ХХК-ийн оёдолчин	ИЗ67070704
4.	Д.Долгормаа	“Бэсэг” ХХК-ийн оёдолчин	ВЭ70050606
5.	Д.Эрдэнэчимэг	“Шинэ-Эхлэл” ТББ-ын оёдолчин	ШЗ66042502
6.	Д.Бадамсүрэн	“Марал” ХХК-ийн захирал	УА62111861
7.	С.Энхбаатар	“Ти-Си-Ти” ХХК-ийн үйлчлэгч	РУ77020104
8.	А.Оюун	“Урт цагаан” ХХК-ийн оёдолчин	ЧР55072268
9.	М.Долгормаа	“Даймонд-Очир” ХХК-ийн менежер	УХ59092203
10.	Н.Чанцалдулам	“Т&G” ХХК-ийн оёдолчин	ЛЖ79112801
11.	Т.Сундуйжав	“Алаг даага” ХХК-ийн оёдолчин	ЧН52030569
12.	П.Уртнасан	Чингэлтэй дүүргийн “Ногоон булан” Ахмадын амралтын үйлчлэгч, угаагч	ДН91052601
13.	Н.Чинзориг	Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны иргэн	ЦБ71062612
14.	В.Баяржаргал	Чингэлтэй дүүргийн 33 дугаар цэцэрлэгийн Туслах багш	ХЗ71112761
15.	П.Нэмэхбаяр	Чингэлтэй дүүргийн 33 дугаар цэцэрлэгийн Бүлгийн багш	КР74070307
16.	Н.Энхмаа	Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны Нийгмийн ажилтан	ХН78012567
17.	Г.Нямхүү	“Т&G” ХХК-ийн оёдолчин	ЖЯ79032523
18.	С.Туяа	“Сооц” ХХК-ийн оёдолчин	ФВ72103106
19.	Ж.Ачиймаа	“Нарлаг тал” ХХК-ийн оёдолчин	ШЕ70072362
20.	Ц.Оюунгэрэл	“Т&G” ХХК-ийн үйлчлэгч	ОЭ64010101
21.	Х.Цэрмаа	Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хорооны Нийгмийн халамж үйлчилгээний ажилтан	УС72112007
22.	Д.Бат-Очир	Чингэлтэй тохижилт үйлчилгээний компанийн ачигч	ВК71051916
23.	А.Отгонбаяр	Чингэлтэй тохижилт үйлчилгээний компанийн ачигч	РЭ91052115
24.	У.Давааням	Чингэлтэй тохижилт үйлчилгээний компанийн ачигч	ЕП59101914
25.	Б.Саруултөгс	Чингэлтэй тохижилт үйлчилгээний компанийн ачигч	ГЕ91022013

26.	Б.Долгормаа	Чингэлтэй тохижилт үйлчилгээний компанийн ЗТҮ	ОР70120109
27.	Б.Батхүү	Чингэлтэй тохижилт үйлчилгээний компанийн ЗТҮ	ИМ89062815
28.	З.Болдбаатар	Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шүүгч	ИЮ80030915
29.	Х.Эрдэнэтуяа	Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шүүгчийн туслах	ХЛ64112404
30.	Ш.Оюунцэцэг	Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шүүгчийн туслах	РЭ80121903
31.	Д.Сүхбаатар	Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны иргэн	ЧС62030572
32.	Ж.Бямбажав	Чингэлтэй дүүргийн 12 дугаар хорооны иргэн	ИС38010511
33.	Г.Доржлагма	Чингэлтэй дүүргийн 8 дугаар хорооны иргэн	ВМ47091301
34.	С.Жавзанпагма	Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны иргэн	ИЦ41052563
35.	Н.Сумъяа	Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хорооны иргэн	ХВ45050106
36.	Д.Цэцэгмаа	Чингэлтэй тохижилт үйлчилгээний компанийн Хог орлогын байцаагч	ОЮ64122900
37.	Ж.Пүрэв	Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хорооны иргэн	ЙД63010507
38.	Д.Алтанцэцэг	Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хорооны иргэн	Х353021162
39.	Т.Жаргалсайхан	Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хорооны иргэн	ХВ61101410
40.	Х.Батжаргал	"Магнит сервис" ХХК-ийн захирал	ХП62120210
41.	М.Гантуяа	"Ажбэ" ХХК-ийн захирал	ХВ69120500
42.	Д.Оюунцэцэг	Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны иргэн	ХН66091021
43.	Э.Орхон	Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны Засаг дарга	ХП60020761
44.	Ц.Минжээ	"Шинэ хос Номин Оюу" ТББ-ын тэргүүн	ХВ61020101
45.	"Медиа тех" ХХК	"Медиа тех" ХХК-ийн хамт олон	9011064025
46.	Б.Мэндбаяр	Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны иргэн	ДИ80072217
47.	Б.Чингэрэл	Чингэлтэй дүүргийн 12 дугаар хорооны иргэн	ЙЮ54041663
48.	Г.Намсрай	Чингэлтэй дүүргийн 16 дугаар хорооны иргэн	ХЛ82100473
49.	Б.Саранбямба	Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны иргэн	УС85022300
50.	Б.Сумъяабаатар	Аврах гал унтраах 10 дугаар ангийн гал сөнөөгч	УК89010913
51.	С.Алтансүх	Аврах гал унтраах 10 дугаар ангийн гал сөнөөгч	ХМ87042971
52.	Ц.Отгонбаяр	Аврах гал унтраах 10 дугаар ангийн жолооч	ПГ81080110
53.	А.Ариунаа	Дүүргийн Эрүүл мэндийн төвийн Эх барих эмэгтэйчүүдийн зохицуулагч их эмч	ЧМ83060409
54.	Х.Уламбаяр	Дүүргийн Эрүүл мэндийн төвийн их эмч	РХ88030619

55.	Н.Одонтуяа	Дүүргийн Эрүүл мэндийн төвийн Дотрын их эмч	УШ81082908
56.	М.Хэрлэн	Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны "Ундрах ирээдүй" өрхийн эрүүл мэндийн төвийн их эмч	Х384051806
57.	Б.Энхтуяа	Чингэлтэй дүүргийн 15 дугаар хорооны "Энэрэнгүй сэтгэл" өрхийн эрүүл мэндийн төвийн их эмч	ЖЬ87040760
58.	Ө.Буянжаргал	Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хорооны "Чинхүслэн" өрхийн эрүүл мэндийн төвийн сувилагч	К378071503
59.	С.Туул	Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны Зохион байгуулагч	ХЕ0121463
60.	Д.Гандолгор	Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны Нийгмийн ажилтан	ЖЭ81011129
61.	Н.Хишигдэлгэр	Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны Хэсгийн ахлагч	ХК52032004
62.	Ж.Батсуурь	Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны Биеийн тамирын арга зүйч	ЧЙ49123119
63.	Н.Түвшинбаяр	Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны "Мэнд цолмон" өрхийн эмнэлгийн ерөнхий эмч	УК76040304
64.	Д.Нямдаваа	Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн ажилтан	
65.	Ч.Хишигдэлгэр	Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны "Мэнд цолмон" өрхийн эмнэлгийн сувилагч	УХ56011901
66.	Ч.Өнөрсайхан	Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны Иргэдийн Нийтийн Хурлын тэргүүлэгч, Нарийн бичгийн дарга	ЧП48012808
67.	Г.Уянга	Чингэлтэй дүүргийн Хөдөлмөрийн хэлтэстэй хамтран үйл ажиллагаа явуулдаг Зээлийн батлан даалтын сангийн бичиг хэрэг, архивын ажилтан	ХЛ77021602
68.	Х.Доржханд	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын Захиралын туслах	ЙС87052906
69.	Ц.Цолмон	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын Хэвлэл мэдээллийн ажилтан	СД78100601
70.	Г.Анхбаяр	Чингэлтэй дүүргийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн Хүнс тэжээлийн судалгаа хариуцсан мэргэжилтэн	ИО78010809
71.	И.Хоролсүрэн	Чингэлтэй дүүргийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн Нэг цэгийн мэргэжилтэн	ЙЮ78090867
72.	Ч.Алтансүвд	Чингэлтэй дүүргийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн Үйл ажиллагааны нягтлан бодогч	УС78102401
73.	Т.Бүжинлхам	Чингэлтэй дүүргийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн хяналт - шинжилгээний үнэлгээ хариуцсан мэргэжилтэн	ТИ83110805

Төлөвлөсөн: Хуулийн зөвлөх бөгөөд хүний нөөц
хариуцсан ажилтан

Г.Сэлэнгэ





**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 79

Улаанбаатар хот

Дүүргийн 2014-2016 оны “Цахим сургууль,
цахим цэцэрлэг” хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн 2014-2016 оны “Цахим сургууль, цахим цэцэрлэг” хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.
2. Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 12 сарын
12-ны өдрийн 79 дүгээр тогтоолын хавсралт



“Цахим сургууль, цахим цэцэрлэг” хөтөлбөр

Нэг. Үндэслэл, хэрэгжих хугацаа

Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын баримт бичигт: “Суралцагчдад хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлнэ.”, “Боловсролын бүх шатны стандарт, сургалтын хөтөлбөрийг тухайн үеийн суралцагчийн хэрэгцээ, нийгмийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгоно.” зэрэг зорилтууд дэвшүүлсэн.

Дүүргийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Цахим сургууль”, “Цахим цэцэрлэг” хөтөлбөрийг хэрэгжүүлж, ерөнхий боловсролын сургуулиудын дэргэд эцэг эх, багш сурагчдад зориулсан “Мэдээллийн төв”-үүдийг байгуулна гэж тусгагдсан.

Мэдээллийн технологи хурдацтай хөгжиж буй өнөө үед багш, сурагчид мэдээ, мэдээлэлд харилцаа, холбооны технологийг хэрэглэн боловсруулалт хийж, сургалтын үйл ажиллагаа, амьдрал ахуйдаа өргөнөөр ашиглах болсон. Сургууль, цэцэрлэг бүр өөрийн гэсэн дэд бүтэц, техник хэрэгслээр хангагдсан боловч хүүхэд хөгжүүлэх сургалтын цахим хэрэглэгдэхүүнийг тасралтгүй боловсруулж ашигладаг тогтолцоог бүрдүүлэх, багш ажлын байрандаа бие даан өөрийгөө хөгжүүлэх, сургалтыг зайнаас онлайн хэлбэрээр явуулах, багш-сурагч-эцэг эхийн хоорондын харилцаа, хамтын ажиллагааг дэмжих, багш, ажилтны өдөр тутмын үйл ажиллагааг хөнгөвчлөх, сургууль, цэцэрлэгийн техник хэрэгслийг шинэчлэх зэрэг асуудлууд орхигдож байгаад дүгнэлт хийж, энэхүү хөтөлбөрийг боловсрууллаа.

Хөтөлбөрийг 2014-2016 онд хэрэгжүүлэнэ.

Хоёр. Өнөөгийн байдал

Тус дүүргийн төрийн өмчийн 14 сургууль, 23 цэцэрлэгт 29155, төрийн бус өмчийн 9 сургууль, 26 цэцэрлэгт 3878, нийт 33033 сурагчид 2047 багш, ажилтан, албан хаагчид ажиллаж, сургалтын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж байна.

Төрийн өмчийн 11 сургууль өндөр хурдны шилэн кабельд холбогдсон, 23 цэцэрлэг зөөврийн интернет ашиглаж байгаа ч төсөвт тус зардал тусгагддаггүй тул ашиглаж буй интернэтийн хурд бага, хамрах хүрээ хязгаарлагдмал байна. Тухайн байгууллагын компьютер бүрийг интернетэд холбох боломжгүй, ашиглаж буй интернет нь шаардлага хангахгүй, хичээлийн хэрэглэгдэхүүн, материал татах бололцоогүй, мөн сургалтын зориулалттай 21 кабинетийн 992 компьютерийн үзүүлэлт хоцрогдсон, нэг компьютерт ногдох суралцагчдын тоо дунджаар 22,3 байна.

Төрийн өмчийн 12 сургуульд 2011 онд орон нутгийн төсвийн 390,0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж, сургалтад ашиглах канон, принтер,

ухаалаг самбар, 20 ширхэг компьютер бүхий цахим анги, 2012 онд Нийслэлийн Засаг даргын санаачилгаар нийслэлийн Мэдээлэл технологийн газар, нийслэлийн Боловсролын газартай хамтран “Багшийн хөгжлийн иновацийн төв”-ийг байгуулан багш ажлын байрандаа хөгжих, хамтран ажиллах, хичээл сургалтаа шинэ технологи ашиглан удирдан зохион байгуулах боломжийг бүрдүүлж ажилласан.

Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилт

Хичээл, сургалтын үйл ажиллагааг орчин үеийн мэдээлэл технологийн давуу талуудыг ашиглан чанартай зохион байгуулж, багш-сурагч-эцэг эхийн хамтын үйл ажиллагааг нээлттэй, хүртээмжтэй болгох замаар сургалтын чанарыг сайжруулж, сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуулийн цахим сургалтын орчныг шинэ шатанд гаргахад хөтөлбөрийн зорилго оршино.

Хөтөлбөрийн зорилтууд:

- Боловсролын байгууллагуудын мэдээллийн технологийн дэд бүтцийг сайжруулах;
- Хичээл, сургалтын үйл ажиллагаанд цахим сургалтын агуулга, арга зүйг түлхүү ашиглах боломжийг бий болгож, багш-сурагчийн үйл ажиллагааг хөнгөвчлөх;
- Цахим мэдээллийн сан бүрдүүлж, сургалтын сайн технологи, шилдэг арга зүйг түгээн дэлгэрүүлэх;
- Зайны /онлайн/ сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулж, багш ажлын байрандаа хөгжих нөхцөл боломжоор хангах;
- Багш-Сурагч-Эцэг эхийн хамтын үйл ажиллагааг нээлттэй, хүртээмжтэй болгох;

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1. “Боловсролын байгууллагуудын мэдээллийн технологийн дэд бүтцийг сайжруулах” зорилтын хүрээнд

- Ерөнхий боловсролын сургуулиудыг өндөр хурдны шилэн кабельд холбох,
- Цэцэрлэгүүдийг өндөр хурдны шилэн кабельд үе шаттайгаар холбох,
- Сургалтад ашиглах компьютерийн тоог нэмэгдүүлэх,
- Сургууль, цэцэрлэгийн гадна талбай, дотно орчныг камержуулна.

4.2. “Хичээл, сургалтын үйл ажиллагаанд цахим сургалтын агуулга, арга зүйг түлхүү ашиглах боломжийг бий болгож, багш-сурагчийн үйл ажиллагааг хөнгөвчлөх” зорилтын хүрээнд

- Багш нарыг цахим сургалтын агуулга, арга зүйг ашиглах чадварт сургах,
- Багш нарын интерактив програмын сургалтанд хамруулах,
- Багш, сурагчийн интернетийн орчинд ажиллах чадварыг сайжруулах,
- Хичээл, сургалтын үйл ажиллагаанд ашиглах цахим хэрэглэгдэхүүний тоог нэмэгдүүлнэ.

4.3. “Цахим мэдээллийн сан бүрдүүлж, сургалтын сайн технологи, шилдэг арга зүйг түгээн дэлгэрүүлэх” зорилтын хүрээнд

- Орон нутгийн удирдлагын мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх,
- Сургалтын сайн технологи, шилдэг арга зүйн сан байгуулж, хөтлөнө.

4.4. Зайны /онлайн/ сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулж, багш ажлын байрандаа хөгжих нөхцөл боломжоор хангах

- Мэргэжлийн хичээлүүдийг цахим хуудастай болгох,
- Мэргэжлийн багш нарыг клубын зохион байгуулалтад оруулж, дэмжих,
- Багш нар хоорондоо байршлаас үл хамааран харилцан сургалтын хөтөлбөр солилцох, хамтран боловсруулах, сайжруулах боломжийг бүрдүүлэх,
- Багш ажлын байрандаа бие даан хөгжих, өөрийн сайн туршлагаа түгээн дэлгэрүүлэх, мэргэжлийн ур чадварт суурилсан нэмэлт орлого олох боломжтой болгоно.

4.5. Багш-Сурагч-Эцэг эхийн хамтын үйл ажиллагааг нээлттэй, хүртээмжтэй болгох зорилтын хүрээнд

- Сургууль /цэцэрлэг/, багш, сурагч, эцэг эхийн харилцаа, хамтын ажиллагааг дэмжих шинэ технологийг нэвтрүүлэх,
- Сургууль, цэцэрлэгийн аюулгүй байдлыг хангах, нэмэлт тоног төхөөрөмж суурилуулах ажлыг дэмжих,
- Орон нутгийн бусад мэргэжлийн болон тусгай чиг үүргийн байгууллагуудтай хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэх,
- Өргөдөл, гомдол, саналыг цахим хэлбэрээр хүлээн авч шийдвэрлэнэ.

Тав. Хөтөлбөрөөс хүлээгдэж буй үр дүн

Мэдээлэл технологийн эрин үетэй хөл нийлүүлсэн, өөрийн мэдлэг боловсрол, чадвараа бүрэн дүүрэн ашиглаж чаддаг бие хүнийг төлөвшүүлэх сургалтын орчныг бүрдүүлсэн байна.

Зургаа. Хөтөлбөрийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

- Улсын төсөв
- Орон нутгийн төсөв
- Төсөл, хөтөлбөр, хандив тусламж
- Бусад эх үүсвэр

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалт

7.1. Хөтөлбөрийг удирдлага, төлөвлөлтөөр хангах, хяналт шинжилгээ хийх, үүргийг Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх Боловсролын хэлтэс хүлээнэ.

7.2. Боловсролын байгууллагыг чадавхжуулах, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх бүтээлч үйл ажиллагааг дэмжих, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, төрийн болон төрийн бус байгууллага, олон нийт, мэргэжлийн байгууллагатай хамтарч ажиллах үүргийг Засаг даргын дэргэдэх Боловсролын хэлтэс.

7.3. Багшийн өдөр тутмын ажлыг хөнгөвчлөх, цахим хэчээлийн хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлэх үүргийг сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд, ерөнхий боловсролын сургуулиуд хариуцна.

7.4. Зайны онлайн сургалт явуулах, шинэ дэвшилтэд технологийг хичээлдээ нэвтрүүлэх үүргийг мэргэжлийн багш нарын клубууд хариуцна.

Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт

- Нэмж өндөр хурдны интернетэд холбогдсон сургууль, цэцэрлэгийн тоо
- Сургалтын зориулалтаар нэмэгдүүлсэн компьютерийн тоо
- Цахим сургалтын хэрэглэгдэхүүн бэлдэх чадвартай багшийн тоо
- Сургууль, багш, сурагч, эцэг эхийн харилцаа, хамтын ажиллагааг дэмжих шинэ технологийг нэвтрүүлсэн эсэх
- Сурагчид бие даан сурах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байдал



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 80

Улаанбаатар хот

Дүүргийн 2014-2016 оны “Манлайлан
суралцагч оюутан, сурагчдыг дэмжих”
хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн 2014-2016 оны “Манлайлан суралцагч оюутан, сурагчдыг дэмжих” хөтөлбөрийг нэгдүгээр, “Манлайлан суралцагчдад сургалтын төлбөрийн тэтгэлэг, урамшуулал олгох журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал /-д даалгасугай.

ДАРГА



Д. БАТ-ЭРДЭНЭ

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 12 сарын 12-ны
өдрийн 80дугаар тогтролын нэгдүгээр хавсралт



Манлайлан суралцагч оюутан, сурагчдыг
дэмжих хөтөлбөр

Нэг. Нийтлэг Үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын баримт бичигт: “Суралцагчдад хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлнэ. Боловсролын бүх шатны стандарт, сургалтын хөтөлбөрийг тухайн үеийн суралцагчийн хэрэгцээ, нийгмийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгоно”, Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт: “... эх оронч сэтгэлгээтэй, амьдрах ухаанд суралцсан иргэн төлөвшүүлэхэд чиглэсэн “Зөв монгол хүүхэд” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ”, “ерөнхий боловсролын сургалтад хүүхэд бүрийг хөгжүүлэх бодлого баримтлан, үндэсний шинэ стандарт нэвтрүүлнэ” зэрэг заалтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд манлайлан суралцагчдаар дамжуулан нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах, тэдний дуу хоолойг шийдвэр гаргах түвшинд хүргэх зэргээр нийгмийн сэтгэлзүйг өөрчлөх шаардлагатай байна. Мөн дүүргийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Манлайлан суралцагч оюутан, сурагчдыг дэмжих тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлнэ” гэж тусгагдсан зэргээс энхүү хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзлээ.

Дүүргийн хэмжээнд төрийн өмчийн 14, төрийн бус өмчийн 9 сургууль сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эдгээрт 23740 хүүхэд багачууд сурч, хөгжиж байна. Үүнээс 750 гаруй төгсөх ангийн суралцагчид байгаа бөгөөд анги дүүргэлт төрийн өмчийн сургуульд дунджаар 35-48 байгаа нь багш хүүхэд нэг бүртэй ажиллах боломжгүй, хүүхэд багшаас өөрийн онцлог, хэрэгцээнд нийцсэн мэдлэг олж авах бололцоо хомс байна. Иймд манлайлан суралцагчдыг дэмжих замаар бусад сурагчдад нөлөөлөх, сурагчийг сурагчаар хөгжүүлэх арга технологийг сургалтанд нэвтрүүлэх нь хүүхэд нэг бүрийн хөгжлийг хангахад давуу тал болох юм.

Хоёр. Хамрах хүрээ, хэрэгжүүлэх хугацаа:

Чингэлтэй дүүргийн харъяат ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, тэтгэлэгт хамрагдсан оюутнуудыг хамрана.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа 2014-2016 он.

Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилт:

Манлайлан суралцагчдад дэмжлэг үзүүлж, тэднээр дамжуулан бусад сурагчдад нөлөөлж идэвх оролцоог нь нэмэгдүүлснээр хүүхэд нэг бүрийн хөгжлийг хангахад багшид дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хөтөлбөрийн зорилт:

- Манлайлан суралцагч оюутан, сурагчдыг дэмжих тэтгэлэг зарлан хэрэгжүүлнэ;
- Хүүхдийн хөгжлийг хангахад чиглэсэн сайн дурын үүсгэл санаачилгыг дэмжинэ ажиллана.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1. Манлайлан суралцагч оюутан, сурагчдыг дэмжих тэтгэлэг зарлан хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:

- Төгсөх ангийн сурагчдийн дунд “Шинэ оюутны тэтгэлэгт хөтөлбөр” зарлан хэрэгжүүлнэ.
- Тэтгэлэгт хамрагдсан суралцагчдад тулгуурлан хүүхдийн хөгжлийг хангахад чиглэсэн төрөл бүрийн сургалт, уралдаан тэмцээнийг зохион байгуулна.
- Манлайлан суралцагчдыг туршлагыг түгээн дэлгэрүүлэх, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна.

4.2. Хүүхдийн хөгжлийг хангахад чиглэсэн сайн дурын үүсгэл санаачилгыг дэмжих зорилтын хүрээнд:

- Бага насны хүүхдийн сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх шатар, даамны дугуйланг ерөнхий боловсролын сургууль тус бүрд хичээллүүлнэ.
- Сурагчийг сурагчаар хөгжүүлэх технологийг бүлгийн хэмжээнд зохион байгуулдаг болно.
- Шилдэг үйл ажиллагаатай бүлгийг шалгаруулж урамшуулдаг тогтолцоог нэвтрүүлнэ.

Тав. Хөтөлбөрөөс хүлээгдэж буй гол үр дүн

Манлайлагч оюутан, сурагчдаар дамжуулан бусад сурагчдад нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулж хүүхэд нэг бүрийн хөгжлийг хангах чиглэлээр багш нарт дэмжлэг үзүүлнэ.

Зургаа. Хөтөлбөрийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

- Орон нутгийн төсөв
- Төсөл, хөтөлбөр, хандив тусламж
- Бусад эх үүсвэр

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалт

7.1. Хөтөлбөрийг удирдлага, төлөвлөлтөөр хангах, хяналт шинжилгээ хийх, үүргийг Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх Боловсролын хэлтэс, Хүүхэд гэр бүлийн хөгжлийн төв хүлээнэ.

7.2. Боловсролын байгууллагыг чадавхжуулах, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх бүтээлч үйл ажиллагааг дэмжих, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, төрийн болон төрийн бус байгууллага, олон нийт, мэргэжлийн байгууллагатай хамтарч ажиллах үүргийг Засаг даргын дэргэдэх Боловсролын хэлтэс, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төв, ерөнхий боловсролын сургууль хариуцна.

7.3. Сурагчийг сурагчаар хөгжүүлэх технологийг бүлгийн хэмжээнд зохион байгуулах ажлыг багш нар хариуцна.

Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт:

- Жилд 3-аас доошгүй оюутныг сурлагын төлбөрийн тэтгэлэгт, 10-аас доошгүй сурагчийн үзүүлсэн амжилтыг харгалзан урамшуулал олгоно.
- Нөлөөллийн үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулагдсан сургалт, уралдаан тэмцээний тоо
- Сурагчийг сурагчаар хөгжүүлэх технологийг хэрэгжүүлж буй бүлгийн тоо
- Шилдэг үйл ажиллагаатай 3-аас доошгүй бүлгийг урамшуулна.
- Бага ангийн сурагчдын 30%-ийг шатар, 50%-ийг даам тоглодог болгосон байна.

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 12 сарын 12-ны
өдрийн 80 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



Манлайлан суралцагч оюутан, сурагчдад
сургалтын төлбөрийн тэтгэлэг, урамшуулал олгох журам

Нэг. Нийтлэг үндэслэл

Тэтгэлэгт хөтөлбөрийг шинэ оюутанд сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох, манлайлан суралцагчийг дэмжин урамшуулах гэсэн 2 замаар хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрт Монгол Улсын аттестатчилагдсан дээд боловсролын байгууллагад бакалаврын зэргээр суралцаж буй оюутан болон ерөнхий боловсролын сургуулийн дүүргийн харъяат суралцагчид хамрагдана.

Хоёр. Шинэ оюутны сургалтын төлбөрийн тэтгэлэг

Үндсэн үзүүлэлт:

- Тэтгэлэгт хамрагдахыг хүсэгч нь ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хөгжлийг хангах чиглэлээр дэвшүүлсэн зорилго, зорилт бүхий үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулсан байна. /Хөтөлбөр нь суралцагчдыг манлайлсан, өөрөө хэрэгжүүлэх бололцоотой, шинэлэг санаа агуулсан байна.
- Сурлагын голч оноо "А" буюу 90-ээс дээш оноотой байна.
- Элсэлтийн ерөнхий шалгалтыг өндөр оноотой өгсөн байх
- Дотоодын их дээд сургуульд зохих журмын дагуу элссэн байх бөгөөд Монгол улсад нэн хэрэгцээт мэргэжлээр суралцаж байгаа бол давуу тал болно.
- Олон нийтийн ажилд бусдыгаа манлайлан оролцдог байх

Бүрдүүлэх материал:

- Дэвшүүлсэн хөтөлбөр
- Анкет /маягтын дагуу/
- Суралцагчийн өргөдөл
- Эцэг, эх асран хамгаалагчийн болон өөрийн иргэний үнэмлэхний хуулбар
- Суралцагчийн хувийн хэргийн хуулбар
- Ерөнхий боловсролын сургуулийн албан ёсны тодорхойлолт.
- Боловсролын үнэлгээний төвийн батламж хуудас /хуулбар/
- Зохих журмын дагуу сургуульд элссэнийг батлах БШУЯ-ны томиллолт
- Хорооны Засаг даргын тодорхойлолт

Гурав. Манлайлан суралцагчийг дэмжих

Үндсэн үзүүлэлт:

- Улс, олон улсын олимпиад, уралдаан тэмцээнд амжилттай оролцсон
- Сурлагын голч дүн "В" буюу 80 хувиас дээш үнэлгээтэй байна.
- Олон нийтийн ажилд бусдыгаа манлайлан оролцдог байх.

Бүрдүүлэх материал:

- Анкет /маягтын дагуу/
- Суралцагчийн өргөдөл
- Эцэг, эх асран хамгаалагчийн болон өөрийн иргэний үнэмлэх /төрсний гэрчилгээ/-ний хуулбар
- Ерөнхий боловсролын сургуулийн албан ёсны тодорхойлолт.
- Суралцагчийн хувийн хэргийн хуулбар
- Суралцагчийн үзүүлсэн амжилтийг гэрчлэх баримт бичгийн хуулбар

Дөрөв. Санхүүжилт

4.1. Сургалтын төлбөрийн тэтгэлэг, урамшууллын хэмжээ болон хамрагдагсдын тоог жил бүр орон нутгийн эдийн засгийн өсөлтэй уялдуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор батална.

4.2. Тэтгэлэг болон урамшуулалд хамрагдахыг хүссэн суралцагчийн өргөдөл, холбогдох материалыг хүлээн авч, хянан баталгаажуулах ажлыг дүүргийн Засаг даргын захирамжаар томилогдсон Ажлын хэсэг шийдвэрлэнэ.

- Суралцагч нь жил бүрийн 8 дугаар сарын 10-ны дотор материалаа дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэст ирүүлнэ.
- Шалгаруулалт зохион байгуулах Ажлын хэсэг ажлын 5 өдөрт багтаан үнэлж нийтэд зарлана. Шаардлагатай тохиолдолд суралцагчаас эх материалыг татан авч үзнэ.



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 81

Улаанбаатар хот

Дүүргийн 2014-2016 оны “Халамжаас
хамгаалалд, хамгааллаас хөдөлмөрт”
хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн 2014-2016 оны “Халамжаас хамгаалалд, хамгааллаас хөдөлмөрт” хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА



Д. БАТ-ЭРДЭНЭ



“Халамжаас хамгаалалд, хамгааллаас хөдөлмөрт”
хөтөлбөр /2014-2016 он/

Нэг. Хөтөлбөрийн үндэслэл, зорилго

Энэхүү хөтөлбөр нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийг 2014-2015 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, дүүргийн Засаг даргын 2012-2016 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөр, 2014 оны нийгэм эдийн засгийн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийгмийн халамж үйлчилгээ авч буй иргэдийн нөхцөл байдал хэрэгцээг үнэлэн, гэр бүл, хамт олонд түшиглэн хөгжүүлж, тэдний оролцоог нэмэгдүүлэх шаардлага урган гарч байна.

Зорилтот бүлгийн иргэдийн нөхцөл байдал хэрэгцээг үнэлэн, гэр бүл, хамт олонд түшиглэн хөгжүүлж, тэдний оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ.

Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.

- Тэгш, хүртээмжтэй, ялгаварлан гадуурхахгүй байх
- Эрэлт хэрэгцээнд нийцсэн байх
- Тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах
- Гэр бүл, олон нийт, салбар хоорондын тэгш оролцоог хангах

Гурав. Хөтөлбөрийн хамрах хүрээ

Нийгмийн халамж үйлчилгээ авч буй хөдөлмөрийн насны иргэд /хөгжлийн бэрхшээлтэй, халамжийн тэтгэмжээс өөр орлогогүй хөдөлмөрийн насны иргэд/, амьдралын баталгаажих түвшингээс доогуур орлоготой орлогыг орлуулан тооцох аргачлалын 1-3 бүлэгт хамрагдах өрхийн иргэдийг цаашид зорилтот бүлэг гэж нэрлэнэ.

Дөрөв. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх зорилт, үйл ажиллагаа

4.1. Зорилтот бүлгийн иргэдийн нөхцөл байдал, хэрэгцээг үнэлэн хөгжлийг дэмжих, оролцоог нэмэгдүүлэх нэгдүгээр зорилтын хүрээнд

4.1.1. Зорилтот бүлгийн иргэдийн нөхцөл байдал, хэрэгцээг хороо бүрээр үнэлэн дүгнэлт хийж, хөгжлийн хэрэгцээг хангах сургалт, хөгжүүлэх, мэдээллээр хангах үйл ажиллагааг гэр бүл, хамт олныг түшиглэн хийх.

4.1.2. Хөгжлийн хэрэгцээ, сонирхлын бүлэг байгуулан ажиллахад ТББ-тай хамтран дэмжих.

4.1.3. Зорилтот бүлгийн иргэдийн хөгжлийг ханган ажилласан байгууллага, ажилтны сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах

4.1.4. Зорилтот бүлгийн иргэдийн санал, хүсэлтийг шийдвэр гаргах түвшинд хүргэх тэдний оролцоог нэмэгдүүлэн дуу хоолойгоо сонсгох,

шийдвэр гаргах үйл ажиллагаанд Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах.

4.2. Зорилтот бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хүртээмжийг нэмэгдүүлэх хоёрдугаар зорилтын хүрээнд

4.2.1. Зорилтот бүлгийн иргэдийн эрүүл мэндээ хамгаалах зан үйл төлөвшүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалтын хувь хэмжээ, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах.

4.2.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг гэр бүл, хамт олонд нь түшиглэн сэргээн засах үйлчилгээг тэдний оролцоотойгоор зохион байгуулж эрүүл мэндийн төвийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх.

4.2.3. Хөнгөвчлөх тусламж шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нарийн мэргэжлийн эмч нарын тусламж, үйлчилгээг ойртуулах.

4.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хамран сургалтыг нэмэгдүүлэх гуравдугаар зорилтын хүрээнд

4.3.1. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн багш нарт “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтанд хамруулах” мэдлэг чавар олгох сургалт зохион байгуулах.

4.3.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн цэцэрлэг, сургуульд суралцах таатай орчныг бүрдүүлэх, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжих.

4.4. Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дөрөвдүгээр зорилтын хүрээнд

4.4.1. Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэх хэрэгцээг үнэлэн, шаардлагатай сургалтанд зуучлах, мэргэжил эзэмших давтан сургалтанд хамруулах, тохирох ажилд зуучлах.

4.4.2. Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөрийн өөртөө туслах бүлгүүдийн үйл ажиллагааг дэмжих.

4.4.3. Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин төсөл хөтөлбөрт хамруулах, арга зүйд сургах.

4.5. Иргэд, аж ахуй нэгж байгууллага зорилтот бүлгийн иргэдийн гэр бүл, хөгжлийг дэмжих тавдугаар зорилтын хүрээнд

4.5.1. Хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх сургалт, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх нийгмийн ойлголт, хандлагыг эерэг болгох, иргэнд ээлтэй орчин бүрдүүлэх, нийгэм хамт олонд түшиглэн сэргээн засах чиглэлээр сурталчилгаа, мэдээллийг хүн амд хүргэх.

4.5.2. Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх ажлыг зохион байгуулахад мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах.

4.5.3. Зорилтот бүлгийн иргэдэд холбогдох хууль эрх зүйн талаарх ойлголт, мэдлэг олгох сургалт зохион байгуулах.

4.6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлдэг төрийн албан хаагчдын ур чадварыг сайжруулах зургаадугаар зорилтын хүрээнд

4.6.1. Төрийн албан хаагчдад “Хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх” талаар мэдлэг олгох сургалт зохион байгуулж, нийгмийн ойлголт, хандлагыг эерэг болгох.

4.6.2. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх.

4.6.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй аж ахуй нэгж, байгууллага шалгаруулах.

Тав. Хөтөлбөрийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

- Улс, нийслэлийн төсөв
- Дүүрэг, орон нутгийн төсөв
- Гадаад дотоодын төсөл хөтөлбөрүүд
- Иргэн, аж ахуй нэгж, байгууллагын хандив тусламж

Зургаа. Хөтөлбөрийн үр дүн

- Зорилтот бүлгийн иргэдийн нөхцөл байдал, хэрэгцээний судалгааг 80%-иас доошгүй иргэдийг хамруулна.
- Зорилтот бүлгийн иргэдийн соёл урлаг, спортын сонирхлын бүлгийг хороо бүрт нэгээс доошгүй байгуулж урлаг, спортын арга хэмжээнд жил бүр 150-с доошгүй хүн хамрагдана.
- Зорилтот бүлгийн иргэдийн санал, хүсэлтийг шийдвэр гаргах түвшинд танилцуулж, шийдвэрлэхэд төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллана.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сэргээн засах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зорилтот бүлгийн 50% хувийг хамруулна.
- Зорилтот бүлгийн иргэдийн мэргэжил эзэмшүүлэх, давтан сургалтанд хамруулах, тохирох ажилд зуучлалт нэмэгдсэн байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өөртөө туслах хөдөлмөрийн 5-аас доошгүй бүлэг байгуулагдаж, тэдний үйл ажиллагааг дэмжин ажилласан байна.
- Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөлд 50-аас доошгүй иргэдийг хамруулна.
- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн багш нарт мэдлэг ур чадвар олгох сургалтыг жилд нэгээс доошгүй зохион байгуулсан байна.
- Хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг цэцэрлэг, сургуульд тус бүр хоёроос доошгүй хамруулна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй гэр бүл рүү чиглэсэн Нийгэм хамт олонд түшиглэн сэргээн засах үйл ажиллагаа, сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран хороо бүрт хоёроос доошгүй удаа 40 гэр бүлд зохин байгуулна.
- Жилд 150-иас доошгүй албан хаагчдыг сургалтанд хамруулж, чадавхжуулах ажлууд хийнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлдэг хоёроос доошгүй төрийн бус байгууллагатай гэрээ хийж ажиллана.
- Жилд хоёроос доошгүй аж ахуй нэгж, байгууллагыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй байгууллагаар шалгаруулсан байна.

- Дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн багш нарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтанд хамруулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурах орчинг 5 доошгүй сургууль, цэцэрлэгт бүрүүлнэ.

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэлбэр, удирдлага, зохицуулалт

7.1. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын хөтөлбөрийн хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.

7.2. Хөтөлбөрт хамрагдсан иргэн, үзүүлсэн үйлчилгээ, хэрэгжилтийн явц, үр дүн, мэдээ, тайланг Хөдөлмөр, нийгмийн хамгаалал хариуцсан мэргэжилтэн гаргана.

7.3. Иргэнд үзүүлэх зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

7.4. Сургалтанд хамрагдах, үйлчилгээ авах иргэдийг хороодын Засаг даргын Ажлын алба хариуцна.

Найм. Хяналт-шинжилгээ, үнэлгээ үнэлгээ хийх, шалгуур үзүүлэлт

8.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг хагас бүтэн жилээр тайлагнана.

8.2. Үнэлгээг зорилтот бүлгийн төлөөлөл, төрийн бус байгууллага, Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэс хамтран хийнэ.

Шалгуур үзүүлэлт

Д/д	Үзүүлэлт	2014 оны /10 сар/	2015 он	2016 он	Хариуцах хэлтэс, албад
1	Зорилтот бүлгийн иргэдийн хөгжлийн хэрэгцээг үнэлсэн үнэлгээний тоо	315	2400	1200	Нийгмийн хөгжлийн хэлтэс, Нийгмийн ажилтны судалгаа
2	Соёл, урлаг спортын арга хэмжээнд хамрагдсан зорилтот бүлгийн иргэдийн тоо	50	120	150	Соёлын төв, Биеийн тамир, спорт хороо, Хороодын нийгмийн ажилтан
3	Зорилтот бүлгийн иргэдийг үзлэг, шинжилгээнд хамруулах үйлчилгээний нэр төрөл	3	5	6	Эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төв
4	Хөнгөн зэргийн бэрхшээлтэй хүүхдийн цэцэрлэгт хамрагдсан тоо	10	20	23	Боловсролын хэлтэс
5	Хөнгөн зэргийн бэрхшээлтэй ХБ хүүхдийн сургуульд	Одоогоор байхгүй	5	10	Боловсролын хэлтэс

	хамрагдсан тоо				
6	Зорилтот бүлгийн иргэдийн мэргэжлийн давтан сургалтанд хамрагдсан тоо	8	20	30	Хөдөлмөрийн хэлтэс
7	Зорилтот бүлгийн иргэдийг ажилд зуучилсан тоо	13	20	30	Хөдөлмөрийн хэлтэс
8	Зорилтот бүлгийн иргэдийн төсөл хөтөлбөрт хамрагдалт Үүнээс ХБИ-ийн төсөл хөтөлбөрт хамрагдалт тоо, мөнгөн дүн	судалгаа -гүй 43 иргэн 50 сая төг	50	60	Хөдөлмөрийн хэлтэс
9	Сургалт үйл ажиллагаанд хамрагдсан гэр бүлийн гишүүд,гэрийн сургагчаар бэлтгэгдсэн ХБИ эцэг эх гэр бүлийн иргэдийн тоо	40 өрх	80	120	Хороодын нийгмийн ажилтан
10	ХБИ-ийн сонирхлын бүлгийн тоо хийгдсэн үйл ажиллагааны тоо	2	3	5	Хорооны засаг дарга



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 82

Улаанбаатар хот

**Дүүргийн 2014-2016 оны “Хотын иргэн-Хотын
соёл” хөтөлбөр батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн 2014-2016 оны “Хотын иргэн-Хотын соёл” хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА  Д. БАТ-ЭРДЭНЭ



1150000193

Terguulegchdiin togtool 2014.doc



"Хотын иргэн - Хотын соёл" хөтөлбөр

Нэг. Хөтөлбөрийн үндэслэл, шаардлага

Монгол улсын үндсэн хууль, Төрөөс баримтлах соёлын бодлого, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Засгийн газраас хэрэгжүүлж буй үндэсний болон дэд хөтөлбөрүүд, дүүргийн Засаг даргын 2012-2016 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөр, Нийгэм, эдийн засгийн зорилтууд нь тус хөтөлбөрийн эрх зүйн үндэслэл болно.

Даяаршил, хотжилт, техник технологийн хөгжлийн нөлөөгөөр суурин соёл иргэншил давамгайлах болсон өнөө үед хүн амын амьдралын хэв маяг өөрчлөгдөж байна. "Миний эрх чиний эрхээр хязгаарлагдана" гэдэгчлэн хүн амын нягтрал ихсэхийн хэрээр нийгмийн амьдралд өөрийн үүргээ биелүүлэн оролцох хэрэгтэй. Хүн нийгмийн харилцаанд орохдоо мэндлэх, хүндлэх, хогоо хогийн саванд хийх, иргэн хүний хувьд бичиг баримтын зөрчилгүй байх гээд наад захын соёлыг төлөвшүүлэх хэрэгтэй. Олон улсын хэмжээний /метрополис/ хотын соёлтой иргэнийг төлөвшүүлэх, хэвшүүлэх, ажиллаж амьдрах таатай орчныг бүрдүүлэх зайлшгүй шаардлага бий болж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1 Хөтөлбөрийн зорилго

2.1.1. Монгол үндэстэн, угсаатан, ястны өв соёл, уламжлал, түүх соёл, зан заншлыг хадгалан хамгаалах, эх түүхээрээ бахархах үзлийг төлөвшүүлэх, харилцан баяжуулах, уламжлан хөгжүүлэх ажлыг зохион байгуулах.

2.1.2. Хотын соёлтой иргэнийг төлөвшүүлэхэд гэр бүлийн соёл, хүмүүжлийн уламжлалыг дээдлэн хөгжүүлж, иргэний үүргээ биелүүлэн бичиг баримтын зөрчилгүй, угийн бичиг хөтлөх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх.

2.1.3. Түүх, соёлын дурсгалт зүйлсийг хадгалан хамгаалах, сурталчлах, соёлын өв тээгчдийг дэмжих.

2.1.4 Хотын иргэний соёлыг төлөвшүүлэх талаар хүүхэд залуучуудад сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах, урлагаар дамжуулах хүмүүжил олгох, төрийн байгууллага, аж, ахуйн нэгж байгууллагууд гадаад, дотоод тохижилт, байгууллагын соёлыг нэвтрүүлэх, хэвшүүлэх.

2.2. Хөтөлбөрийн зорилтууд

2.2.1. Эх орон, түүхээрээ бахархдаг, иргэний үүргээ биелүүлэн бичиг баримтын зөрчилгүй, амьдрах орчноо тохижуулан, хайрлан хамгаалсан, гэр бүлийн соёл хүмүүжлийг дээдлэн угийн бичиг хөтөлсөн иргэн, өрхийг бий болгох.

2.2.2. Үйлчилгээний соёлыг хэвшүүлсэн, гадаад, дотоод тохижилт, тохитой орчныг бүрдүүлсэн, үйлчлүүлэгчээ дээдэлсэн байгууллага, аж ахуйн нэгжийг нэмэгдүүлэх, хэвшүүлэх

Гурав. Хөтөлбөрийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Метрополис: Дэлхийн хэмжээний томоохон хот

3.2.Төрийн байгууллага: Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургууль

Дөрөв. Хөтөлбөрийн хамрах хүрээ

4.1. Төрийн байгууллага, ажилтан албан хаагч

4.2. Дүүргийн иргэн, хүүхэд, залуучууд

4.3. Аж ахуй нэгж, байгууллага

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам, зарчмууд

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараахь зарчмуудыг баримтална.

5.1.1. Төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжин, соёлын үйл ажиллагаанд гэр бүл, иргэдийн тэгш оролцоог хангах, хотын соёлтой иргэнийг төлөвшүүлэх чиглэлээр шинэлэг санал, санаачлагыг дэмжинэ.

5.1.2. Ирээдүйн хотын иргэнийг бага наснаас нь хүмүүнлэг, оюунлаг, соёл, эх түүх, уламжлалаа нандигнан дээдэлдэг “Хотын соёлтой иргэн” төлөвшүүлэхэд бүх шатны боловсролын байгууллагатай хамтар, дэмжин ажиллана.

5.1.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг соёлын үйл ажиллагаанд хамруулах, идэвхтэй оролцуулах, түүний авьяас чадвар, хөдөлмөр бүтээлийг дэмжинэ.

5.1.4. Гэр бүлийн соёл, хүмүүжил, уламжлалыг дээдлэх, угийн бичиг хөтлөх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд бүх шатанд хэрэгжүүлнэ.

5.1.5. Түүх соёлын дурсгалт зүйлсийг хадгалан хамгаалах, сурталчлах, соёлын өвийг өвлөн тээгчийн бүтээн туурвих өвөрмөц дэг сургуулиа өвлүүлэн үлдээхэд дэмжлэг үзүүлнэ.

Зургаа. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хүрэх үр дүн

6.1. Эх орон, түүхээрээ бахархдаг, иргэний үүргээ биелүүлэн бичиг баримтын зөрчилгүй, амьдрах орчноо тохижуулан, хайрлан хамгаалсан, гэр бүлийн соёл хүмүүжлийг дээдлэн угийн бичиг хөтөлсөн иргэн, өрхийг бий болгох зорилтын хүрээнд

6.1.1. Хүүхэд багачуудыг соёл урлагаар дамжуулан төлөвшүүлэх, боловсрол олгох, үндэсний урлагийг сурталчлан таниулах, өвлүүлэх зорилгоор төрөл бүрийн уралдаан тэмцээнийг зохион байгуулж гоц авьяастай хүүхэд багачуудыг дэмжих,

6.1.2. Монголын түүх, соёл, хэл бичгийн соёл, ёс заншил, өв уламжлалаа таниулах, эх оронч үзлийг төлөвшүүлэх ажлыг төрийн болон төрийн бус

байгууллага, нийгэм, гэр бүл боловсролын байгууллагаар дамжуулан өв тэгш нийслэлийн иргэнийг төлөвшүүлэх,

6.1.3. Эх хэл, бичиг соёлоо сурталчлах, номтой нөхөрлөх аян зохион байгуулах,

6.1.4. Төрийн болон төрийн бус байгууллага, бүх шатны боловсролын байгууллагатай хамтран үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, цус ойртолтоос сэргийлэх, удам угсаагаа мэдэх зорилгоор угийн бичиг хөтлөх ажлыг эрчимжүүлэх, хөтлөгч өрхийн тоог нэмэгдүүлэх,

6.1.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг нийгэм соёлын харилцаанд оруулан идэвхижүүлэх, тэдний авьяасыг нээх, хөгжүүлэх,

6.1.6 Дүүргийн хэмжээнд бичиг баримтгүй иргэдийг баримтжуулах, зөрчлийг арилгана.

6.2. Үйлчилгээний соёлыг хэвшүүлсэн, гадаад, дотоод тохижилт тохитой орчныг бүрдүүлсэн, үйлчлүүлэгчээ дээдэлсэн байгууллага, аж ахуйн нэгжийг нэмэгдүүлэх, хэвшүүлэх, ахуйн болон нийтийн соёлыг төлөвшүүлэх

6.2.1. Төрийн байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, бүх шатны боловсролын байгууллагууд гадна талбай, дотоод орчны тохижилтыг хийн, өөрийн эзэмшлийн зам талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх,

6.2.2. Үйлчилгээний соёл, ахуйн соёлыг дээшлүүлэх сургалт, сурталчилгаа хийх, болзолт уралдаан зарлан идэвхижүүлэх,

6.2.3. Хороод айл өрхийг гаднах үзэмж, орчныг сайжруулах, эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэн хашаа гудамжиндаа ногоон байгууламж, гэрэлтүүлэг нэмэгдүүлэх,

6.2.4. Иргэдийн соёл, хөгжлийн хэрэгцээний судалгааг гарган, нийтийн соёлыг дээшлүүлэх зорилгоор хороод, айл өрх, аж ахуйн нэгжийн дунд ахуйн, нийтийн, үйлчилгээний соёлын хөдөлгөөн өрнүүлэн уялдаа холбоог сайжруулан хамтран ажиллах,

6.2.5. Хөгжлийн хэрэгцээнд түшиглэсэн соёл урлаг, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг иргэний танхимыг түшиглэн явуулж, тогтмолжуулах, иргэдийг сонирхлын бүлгээр нь сайн дурын хамтлаг, урлагийн клубууд байгуулан ажиллахад дэмжлэг үзүүлнэ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх:

“Соёлтой иргэн”-ийг төлөвшүүлэхэд:

- Харилцааны соёл, хогоо зориулалтын саванд хаях, ил задгай биеэ засахгүй, үйлчилгээний газар биеэ зөв авч явах соёлыг төлөвшүүлэх талаар сургалт, сурталчилгааг хийж хэвших
- Нийтээр дагаж мөрдөх дүрэм журам, хэм хэмжээг, замын хөдөлгөөний дүрэм, бусад хүний эрхийг хүндэтгэж иргэний үүргээ ёсчлон биелүүлэх.

“Соёлтой өрх, гэр бүл”-ийг төлөвшүүлэхэд:

- Гэр бүлийн хүмүүжлийг дээдэлсэн, эцэг эхийн үүргээ биелүүлэн үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх
- Гэр бүлийн ёс заншил, удам угсаагаар бахархах, угийн бичиг хөтлөх

- Иргэний үүргээ биелүүлэн цахилгааны төлбөр, хогны тооцоог цаг бүрт нь төлөх
- Эрүүл, аюулгүй тохитой орчин бүрдүүлэх

“Соёлтой байгууллага”-ыг төлөвшүүлэхэд:

- Аж ахуйн нэгж бүр өөрийн үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан байгууллагын харилцааны соёл, гадна, дотоод тохитой орчинг бүрдүүлэх

Төрийн байгууллага:

- Байгууллагын ажилтан албан хаагчдын харилцааны соёл, мэндлэх, хүндлэх соёлыг бий болгох
- Байгууллагын дотор эмх цэгцтэй суух, хувцаслалтанд анхаарах
- Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн, шуурхай хүртээмжтэй хүргэх
- Төрийн албан хаагчдын ёс зүйн хэм, хэмжээ, эрхэмлэх зүйлсийг мөрдөн ажиллах

Соёл, урлагийн байгууллага:

- Соёл урлагийн үйлчилгээг иргэдэд хүргэхдээ цагийн хуваарийг нарийн баримтлан ажиллах
- Үйлчилгээний соёл, мэндлэх, угтах, үдэх, харилцааны соёлыг төлөвшүүлэх
- Угтан авах үйлчилгээний ажилтан ижил хувцсаар жигдрэх
- Соёл, урлагийн төрөл зүйлсээр дамжуулан иргэдийн чөлөөт цагийн зөв өнгөрүүлэх, соён гэгээрүүлэнх ажлуудыг төлөвлөгөөнд тусган, хийж занших

Үйлчилгээний байгууллага

- Байгууллагын үйлчилгээний ажилтнууд цэвэр, цэвэр жигд хувцасласан байх
- Мэндлэх, хүндлэх угтах, үдэх үйлчилгээ, харилцааны соёлыг хэвшүүлэх
- Үйлчлүүлэгчдэд таатай орчинг бүрдүүлэн гадна, дотоод орчныг тохижуулах, өөрийн болон нийтийн эзэмшлийн зам талбайг цэвэрлэж занших
- Эрүүл цэвэр орчныг бүрдүүлэхээр цэцэг ногоон орчныг бүрдүүлэх

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат, санхүүжилт

7.1. “Хотын иргэн-Хотын соёл” хөтөлбөрийг 2014-2016 оны хооронд хэрэгжүүлнэ.

7.2. Хөтөлбөрийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

7.2.1. Улс, нийслэлийн төсөв,

7.2.2. Орон нутгийн төсөв,

7.2.3. Төсөл хөтөлбөрийн зардал

Найм. Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт

8.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд удирдлага төлөвлөлтөөр Засаг даргын Тамгын газар, Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хөгжлийн хэлтэс ханган ажиллана.

8.2. “Хотын иргэн - Хотын соёл” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилт, холбогдох журам, хөрөнгийг дүүргийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлүүлнэ.

8.3. Соёлын төв нь хороо, аж ахуйн нэгж, байгууллагыг арга зүйгээр хангаж манлайлан оролцоно.

8.4. Хөтөлбөрийг орон нутгийн хэмжээнд иргэд, төрийн байгууллага, хороо, аж ахуйн нэгж, байгууллага хэрэгжүүлэн ажиллана.

Ес. Хөтөлбөрийн үр дүн

9.1. Монгол улсын төрөөс баримтлах соёлын бодлого, Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2012-2016 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Хотын иргэн-Хотын соёл” хөтөлбөрийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлнэ.

9.2. Соёл урлагаар дамжуулан хүүхэд, залуучуудыг төлөвшүүлэх олон төрлийн уралдаан тэмцээн зохион байгуулна.

9.3. Эх түүхээрээ бахархсан, иргэний үүргээ биелүүлэн бичиг баримтыг зөрчилгүй, амьдрах орчноо тохижуулан, хайрлан хамгаалсан, гэр бүлийн соёл хүмүүжлийг дээдлэн угийн бичиг хөтөлдөг “Хотын соёлтой иргэн”-ийг төлөвшүүлнэ.

9.4. Үйлчлүүлэгчээ дээдэлсэн харилцаа, үйлчилгээний соёлыг хэвшүүлсэн, гадаад, дотоод тохижилт, тохитой таатай орчин бүрдэнэ.

9.5. Төрийн байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, бүх шатны боловсролын байгууллагууд гадаад, дотоод тохижилтыг хийн, өөрийн эзэмшлийн зам талбайд ногоон байгууламж нэмэгдэнэ.

9.6. Хотын соёлыг төлөвшүүлэх талаар хүүхэд залуучуудад сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах, урлагаар дамжуулан хүмүүжил олгох, Төрийн байгууллага, Аж, ахуйн нэгж байгууллагууд гадаад, дотоод тохижилт сайжирч, байгууллагын соёлыг нэвтрүүлнэ.

Арав. Шалгуур үзүүлэлт

10.1. Соёл урлагийн уралдаан тэмцээний төрөл, оролцогчдын тоог 2 дахин нэмэгдүүлнэ.

10.2. Музейгээр үйлчлүүлэх хүүхэд багачуудын тоог 5000 хүргэнэ.

10.3. Угийн бичиг хөтлөх өрхийн тоог 5000 хүргэнэ.

10.4. Жил бүр хөшөө, дурсгалыг сэргээн засварлахад шаардлагатай төсвийг суулган, сэргээн засварлана.

10.5. Хороо бүрт урлагийн клубыг бий болгон, үйл ажиллагааг тогтмолжуулна.

10.6. Соёлтой иргэн, өрх, байгууллагад хэвшүүлэх дадалыг боловсруулан, сурталчлана.

10.7. Дүүргийн айл өрх, байгууллагын соёлыг үнэлэх шалгуур хэмжүүртэй болж, жил бүр үзүүлтийн дагуу шалгаруулан, сайн туршлагыг нэвтрүүлнэ.



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 83

Улаанбаатар хот

Дүүргийн 2014-2016 оны “Нийгмийн
баталгааг хангах” хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн 2014-2016 оны “Нийгмийн баталгааг хангах” хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д үүрэг болгосугай

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА



Д. БАТ-ЭРДЭНЭ

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 12 сарын 12-ны
өдрийн 83 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



Дүүргийн төрийн албан хаагчдын “Нийгмийн
баталгааг хангах” хөтөлбөр

Нэг. Үндэслэл, зорилго, зорилт

1.1. Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль, Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр нь төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулах хууль эрх зүйн үндэслэл болно.

1.2. Төрийн албан хаагчдын ажиллаж, амьдрах нөхцөл бололцоог сайжруулах асуудлын хүрээнд ажиллах таатай орчныг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах, үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажиллах боломжоор хангах, албан хаагчдын эрүүл мэнд ажил, амралтын зохистой харьцааг тогтоох, чөлөөт цагийг зохистой өнгөрүүлэх, ажлын байранд мэргэшүүлэх ур чадварыг дээшлүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

1.3. Хөтөлбөрийн зорилт:

- 1.3.1. Ажиллах орчныг бүрдүүлэх,
- 1.3.2. Нийгмийн баталгааг хангах,
- 1.3.3. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах
- 1.3.4. Чөлөөт цагийг зохистой өнгөрүүлэх нөхцөл боломжоор хангах
- 1.3.5. Албан хаагчдыг үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажиллуулах,

Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ

2.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг Засаг даргын Тамгын газар хариуцах бөгөөд жил улирлын үйл ажиллагааны төлөвлөгөөнд үе шаттайгаар тусгаж хэрэгжүүлнэ.

2.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг байгууллагын жилийн төсөвт тусган санхүүжүүлнэ. Боломжит бусад эх үүсвэрийг идэвхтэй эрэлхийлж ашиглана.

2.3. Ажиллах таатай орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд

- 2.3.1. Өрөө тасалгаа, танхимыг үе шаттайгаар засч тохижуулна.
- 2.3.2. Аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг чанд мөрдөн ажиллана.
- 2.3.3. Ажлын багаж, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг бүрэн хангасны дараа ашиглаж, аюулгүй байдлын дүрэм журмыг мөрдөөгүйгээс эсвэл ажилтай холбоогүй учирсан гэмтэл, хохирлын хариуцлагыг байгууллага хүлээхгүй болохыг анхааруулж байна.
- 2.3.4. Албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас албан хаагчийг хамгаалах арга хэмжээ авна.
- 2.3.5. Албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан төрийн жинхэнэ албан хаагчийн биед гэмтэл учирсан тохиолдолд эмчилгээний зардлын тодорхой хэсгийг олгоно.

2.4. Нийгмийн баталгааг хангах зорилтын хүрээнд:

- 2.4.1. Хуульд заасан үндэслэлээс бусад тохиолдолд төрийн албанаас чөлөөлөхгүй.
- 2.4.2. Холбогдох хууль тогтоомжийн дагуу албан хаагчийн цалин болон урамшуулал, нэмэгдлийг тухай бүр шинэчлэн олгоно. Цалингийн шатлалыг нэмэгдүүлэхдээ албан хаагчдын ажлын ачаалал, үүрэг хариуцлага, мэдлэг чадвар, ажилласан жил болон ажлын үр дүнг харгалзана.
- 2.4.3. Албан хаагчдын үр дүнгийн үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан зэрэг дэв нэмэгдүүлэх асуудлыг тухай бүр нь шийдвэрлэнэ.
- 2.4.4. Үр дүн гэрээний гүйцэтгэл биелэлтэд тулгуурлан дүгнэж стратеги зорилтыг ханган ажиллахад оруулсан хувь нэмэр, бүтээлч санал санаачлага оролцоо, үр дүнд тулгуурлан урамшуулал олгоно.
- 2.4.5. Ажил, амралтын цаг, чөлөө авах, ээлжийн амралт, албан томилолт, цалин хөлс, шагнал, урамшуулал, тэтгэмж, буцалтгүй тусламж нөхөх олговор олгохтой холбоотой харилцааг холбогдох хууль тогтоомж, дотоод журмын хүрээнд оновчтой зохион байгуулж ажиллана.
- 2.4.6. Тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж байгаа албан хаагчдыг орон сууц, хашаа байшин худалдан авахад хөнгөлөлттэй зээлд хамруулах, орон сууц худалдан авах нөхцөл сайжруулахад нь байгууллагаас санхүүгийн дэмжлэг тусалцаа үзүүлж шийдвэрлэх арга хэмжээг дэс дараатай авна.
- 2.4.7. Зуслангийн болон хувийн байшин барих, ногоо тарих, ахуйн зориулалтаар газар эзэмшүүлэх ажлыг зохион байгуулна.
- 2.4.8. Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг хэрэглээний үнийн түвшинг харгалзан тухай бүр шинэчлэн тогтооно.
- 2.4.9. Ганц бие, өрх толгойлсон болон шинээр гэр бүл болсон залуу гэр бүлд эд хөрөнгийн болон санхүүгийн тусламж, дэмжлэг үзүүлнэ.
- 2.4.10. Гадаад, дотоодын төрөл бүрийн аялал, жуулчлалыг бүрэн дэмжинэ.
- 2.4.11. Байгууллагын шийдвэрээр ажлаас чөлөөлөгдөхгүйгээр сургалт, курст хамрагдсан ажилтанд суралцсан хугацаанд нь албан тушаалын цалинг нь олгоно. Ажиллахын зэрэгцээ мэргэжил болон гадаад хэл эзэмших, эрдмийн зэрэг хамгаалах сонирхолтой ажилтнуудад суралцах, шалгалт, өгөх боломжоор хангана.
- 2.4.12. Тогтвор суурьшилтай ажиллаж байгаа үндсэн албан хаагчдад оюуны мэдлэг мэргэжлээ дээшлүүлэхэд нь байгууллагын зүгээс дэмжлэг үзүүлнэ.
- 2.5 Албан хаагчдын эрүүл мэндийг сахин хамгаалах, чөлөөт цагийг зохистой өнгөрүүлэх нөхцөл боломжоор хангах зорилтын хүрээнд
- 2.5.1. Албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан төрийн жинхэнэ албан хаагчийн биед гэмтэл учирсан тохиолдолд эмчилгээний зардлын тодорхой хэсгийг олгоно.
- 2.5.2. Чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, амралт, соёл, урлаг, спорт, бие бялдаржуулах чиглэлийн ажлыг тогтмол зохиож, байгууллагуудтай хамтран ажиллана. Биеийн тамир, спортын хорооны спортын заалыг хуваарийн дагуу тогтмол ашиглана.
- 2.5.3. Цасны баяр, явган болон тойрон аялал зэргийг жилд 1-ээс доошгүй зохион байгуулна.
- 2.5.4. Албан хаагчийг гадаадад эмчлүүлэхэд дэмжлэг тусалцаа үзүүлнэ.
- 2.5.5. Дүүргийн амралтын газруудад амрах журмыг батлаж мөрдүүлнэ.

2.6. Үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилтын хүрээнд

2.6.1. Албан хаагчдын нийгмийн асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн, шийдвэрлэж байгаа талаарх, албан хаагчдын ажилласан жил, зэрэг дэв, шагнал урамшуулал олгосон тухай судалгааг жил бүр 2-оос доошгүй удаа шинэчлэж дүүргийн хэмжээнд хүний нөөцийн нэгдсэн судалгаатай болно.